

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Э.Уранбилэг*, Н.Батдэлгэр**

Хураангуй: Эрчим хүчний салбар нь дэд бүтцийн тулгуур салбар бөгөөд улс орны эдийн засгийн хөгжилтэй салшгүй уялдаатай байдаг. Сүүлийн жилүүдэд хүн амын төвлөрөл, хэрэглэгчдийн өсөн нэмэгдэх хэрэглээ, нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан төвийн бүсийн эрчим хүчний салбар чадлын дутагдалд орж эхэлсэн. Эрчим хүчний үйлдвэрлэгчдийн өнөөгийн суурилуулагдсан хүчин чадлаар эрчим хүчний хэрэглээг хангахгүй нөхцөл байдалд хүрсэн бөгөөд 2022 онд эрчим хүчний салбарын алдагдал 187 тэрбум, 2023 онд 98 тэрбум төгрөгт хүрсэн байна. Алдагдлын үзүүлэлт нь эрчим хүчний салбарт үнэ тарифын томоохон өөрчлөлтийг хийх шаардлага тулгараад байгааг илтгэж байна. Уг судалгаа нь эрчим хүчний салбарын үнийн өөрчлөлт хийх үед олон нийтийн зүгээс ямар эсэргүүцэл тулгарч болохыг ойлгох, үнэ тарифын өөрчлөлт хийх үйл ажиллагааг нийгмийн бүлгүүдэд хэрхэн нөлөөлж болохыг ойлгосноор оновчтой шийдэл боловсруулах, өөрчлөлтийн үйл явцыг хэрхэн чиглүүлэх талаарх шийдэл олоход чиглэгдэнэ. Судалгааг санамсаргүй түүврийн болон, зорилгод түүврийн аргаар төвийн бүсийн эрчим хүчний системийн 510 хэрэглэгчийг хармуулан авсан бөгөөд эрчим хүчний салбарын талаарх ойлголтын зөрүүнээс хамаарсан ялгаатай байдлыг судлахыг зорив. Судалгааны үр дүнгээс харахад эрчим хүчний үнэ тарифыг нэмэхийг нийт оролдогчдын олонх нь дэмжиж байгаа бөгөөд ямар нэгэн байдлаар нэмэхийг хүлээн зөвшөөрч байна. Гэсэн хэдий боловч эрчим хүчний салбарын талаарх маш сайн мэдээлэлтэй бүлэг ч эрчим хүчний үнэ тарифыг бүрэн чөлөөлөхийг дэмжихгүй хандлагатай байна. Мөн үнэ тарифын өөрчлөлтийн хувьд харьцангуй хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх хандлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Түлхүүр үгс: Эрчим хүчний үнэ тариф, үнийн мэдрэмж, өөрчлөлтийн менежмент, өөрчлөлтийн эсэргүүцэл

A COMPARATIVE STUDY ON PUBLIC ATTITUDES TOWARDS ENERGY TARIFFS

Abstract: The energy sector is the backbone of infrastructure, playing a crucial role in the country's economic development. In recent years, due to population growth, rising consumer consumption, and socio-economic changes, the power sector in the central region has begun to experience capacity shortages. The current installed capacity of energy producers has reached a point where energy consumption demands cannot be met. Consequently, the energy sector incurred losses of 187 billion MNT in 2022 and 98 billion MNT in 2023. The deficit underscores the need for significant changes in energy tariffs. The research aims to understand public opposition to energy sector tariff changes, analyze how these changes affect different social groups, develop optimal solutions in response to price changes, and identify strategies for managing the transition process. The study was conducted among 510 consumers of the central region's energy system using random and purposive sampling. It aimed to investigate differences in perceptions of the energy sector. According to the survey results, the majority of participants support an increase in energy tariffs and accept it to some extent. However, even the most well-informed group about the energy sector tends not to support full energy tariff liberalization. Additionally, the research results indicate a tendency to accept changes in prices and tariffs within a relatively limited range.

Keywords: energy tariffs, tariff sensitivity, change management, resistance to change

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): 22m1num0215@stud.num.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batdelger.n@num.edu.mn

1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ:

Эрчим хүчний салбарын оноогийн нөхцөл байдал

Эрчим хүчний салбарын оноогийн нөхцөл байдал Монгол Улсын эрчим хүчний салбар нь 5 бүсээс бүрдэнэ. Нийт томоохон 6 Дулааны цахилгаан станц /ДЦС/, Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл /Нарны, салхины, усан/, Дизель цахилгаан станц гэсэн эх үүсвэрүүд нь эрчим хүчний үйлдвэрлэлийг явуулдаг. Эрчим хүчний үйлдвэрлэлийн нийт суурилсан чадал 1,578.6 МВт юм (Диспетчерийн үндэсний төв, 2022 он). Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ түгээлтээр 9,361.6 сая кВт цаг хүрсэн ба үүний 77.2 % буюу 7,224.3 сая кВт цагийг дотоодын эх үүсвэрээр хангаж, 22.8 %-ийг ОХУ болон БНХАУ-аас импортоор авчээ. 2020-оос 2022 оны гурван жилийн статистик мэдээллээс авч үзвэл, цахилгаан эрчим хүчний импортын хэмжээ 2020 оны 154 сая кВт.цагаас, 2021 онд 333 сая кВт.цаг, 2022 онд 510 сая кВт.цаг болж өсжээ (Диспетчерийн үндэсний төв, 2022 он).

Эрчим хүчний системд оролцогчдын хэрэглээ нь өвлийн улирлын хүйтэн өдрүүдэд болон эрчим хүчийг хамгийн их хэрэглэдэг 17-20 цагийн хооронд системийн суурилуулагдсан хүчин чадлаас давж ачаалал үүсгэхийг оргил ачаалал гэдэг. Нэгдсэн системийн оргил ачаалал 2022 оны 12 дугаар сарын 16-нд 1,469 МВт хүрч өнгөрсөн оны гүйцэтгэлээс 82 МВт-аар өссөн байна. (Диспетчерийн үндэсний төв, 2022 он). 2023 оны 12-р сарын 20-ны өдрийн 19 цагт Төвийн бүсийн системийн оргил ачаалал 1,636 МВт хүрч, импорт 311МВт хүрсэн нь түүхэн өндөр үзүүлэлт болсон (Эрчим хүчний зохицуулах хороо, 2023/12/21). Энэ нь өнгөрсөн оны оргил ачаалаас 11.3%-иар өссөн үзүүлэлт бөгөөд энэ нь өнөөдрийн үйлдвэрлэлийн хүчин чадлаар хэрэглэгчийн өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах боломжгүйд хүрээд байна.

Хүснэгт 1 Эрчим хүчний үйлдвэрлэлд төлж байгаа 1 кВт.цаг төлбөрийн дүн

Төлбөр /сая төг	Он			Өөрчлөлт	
	2020 он	2021 он	2022 он	2020-2021	2021-2022
Дулааны цахилгаан станц*	420,292	499,439	509,027	119%	102%
Салхин цахилгаан станц**	106,104	150,065	151,098	141%	101%
Нарны цахилгаан станц***	42,189	68,677	76,056	163%	111%
Импорт	40,942	83,231	154,292	203%	185%
Нийт	609,528	801,412	890,473	131%	111%
Үйлдвэрлэл /сая кВт.цаг/	2020 он	2021 он	2022 он	2020-2021	2021-2022
Дулааны цахилгаан станц	4,711	5,847	6,108	124%	104%
Салхин цахилгаан станц	398	556	503	140%	90%

Нарны цахилгаан станц	96	154	159	159%	103%
Импорт	154	333	510	216%	153%
Нийт	5,360	6,889	7,279	129%	106%
Нэг кВт цахилгааны үнэ /төг/	2020 он	2021 он	2022 он	2020-2021	2021-2022
Дулааны цахилгаан станц	89.2	85.4	83.3	96%	98%
Салхин цахилгаан станц	266.3	269.7	300.7	101%	111%
Нарны цахилгаан станц	437.9	447.4	478.8	102%	107%
Импорт	265.5	250.2	302.8	94%	121%
Дундаж	113.7	116.3	122.3	102%	105%

Эх сурвалж: (Диспетчерийн үндэсний төв, 2020,2021,2022 он)

Тайлбар: *Дулааны цахилгаан станцад ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, ДДЦС, ЭДЦС, ЭҮ-ийн ДЦС, ДАЛ ДЦС, Ухаахудаг, **Салхин цахилгаан станцад Салхит СЦС, Цэций СЦС, Сайншанд СЦС, *** Нарны цахилгаан станцад Нар НЦС, Моннаран НЦС, Гэгээн НЦС, Сүмбэр НЦС, Бөхөг НЦС, Говь НЦС-иудын мэдээллийг нэгтгэв.

Үйлдвэрлэгч талаас эрчим хүчний үйлдвэрлэлд ДЦС, СЦС, НЦС, импорт гэсэн оролцогч талууд оролцож байгаа бөгөөд уг оролцогч талуудаас эрчим хүчний өртөг нь хамгийн өндөр НЦС-ууд байна. НЦС-ууд нь 2022 онд нэгж худалдан авагчаас нэг кВт.цагийн төлбөрт дунджаар 478 төгрөгөөр үйлдвэрлэсэн нь үйлдвэрлэлийн дундаж өртгөөс 3.91 дахин их байна. Харин импортын эрчим хүчний хувьд 302 төгрөг байгаа нь хэрэглэгчийн төлж байгаа дундаж үйлдвэрлэлийн өртгөөс 2.4 дахин их байна (Хүснэгт 1).

Төрөөс эрчим хүчний үнэ тарифыг хязгаарлах бодлого³ баримталж ирсэн нь эрчим хүчний салбарын алдагдалд оруулах үндсэн шалтгаан болсон бөгөөд 2022 онд алдагдал 187 тэрбум, 2023 онд 98 тэрбум төгрөгт хүрсэн байна (Эрчим хүчний зохицуулах хороо, 2023). Монгол Улсын Засгийн газар, УИХ эрчим хүчний салбарыг онцгой анхаарч, УИХ-аас 2021 онд баталсан Шинэ сэргэлтийн бодлогын хоёрдугаар тэргүүлэх чиглэлд эрчим хүчний сэргэлт гэж томьёолон, эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулах, сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэх зэргийг бодлогын түвшинд тусгасан (УИХ, 2021). Шинэ сэргэлтийн бодлогод “Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ” гэсэн томоохон чиглэлийг тусгасан нь цаашид эрчим хүчний үнийг чөлөөлөх, зах зээлийн уян хатан механизм бүрдүүлэх гэсэн утгыг илэрхийлж байгаагаас гадна, олон улс төрчид үнэ чөлөөлөх хэрэгцээ

³ 2021 онд үндэсний аудитын хорооноос явуулсан аудитын дүгнэлтийн 3-р хэсэгт эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагаанд оролцож, эрчим хүчний үнэ тарифыг хязгаарласан, өртгөөс багаар тооцоосон буюу ЭХЗХ-г харуут бус үйл ажиллагаа явуулахад нь саад учруулсан гэж тэмдэглэсэн байна

шаардлагын талаар олон нийтэд мэдээлэл хийсэн байна⁴. Эрчим хүчний салбарын асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр боловсруулах үйлдвэрлэлийн дэмжих, хөгжүүлэх, эдийн засгийг солонгоруулах асуудал шийдэгдэхгүй.

Судалгааны зорилго нь одоогийн мөрдөгдөж байгаа эрчим хүчний үнэ тарифын талаар хэрэглэгчид болон олон нийтийн зүгээс ямар хандлагатай байгааг тодорхойлох, үнэ тарифын өөрчлөлт хийхэд ямар эсэргүүцэл тулгарч болохыг судлах юм. Энэ нь цаашид эрчим хүчний салбарын үнийн өөрчлөлт хийх үед олон нийтийн зүгээс ямар эсэргүүцэл тулгарч болохыг ойлгох, үнэ тарифын өөрчлөлт хийх үйл ажиллагааг нийгмийн бүлгүүдэд хэрхэн нөлөөлж болохыг ойлгосноор оновчтой шийдэл боловсруулах, өөрчлөлтийн үйл явцыг хэрхэн чиглүүлэх талаарх шийдэл олоход чиглэгдэнэ. Судалгааны дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Олон нийтээс авах санал асуулгын анкетыг боловсруулах
- Эрчим хүчний салбарын талаар олон нийтийн ойлголт мэдээллийн түвшнийг судлах
- Салбарын талаарх ойлголттой хэрэглэгч болоод ойлголтгүй хэрэглэгчдийн хооронд ялгаа байгаа эсэх талаар судлах,

Судалгааны таамаглалын хувьд дараах таамаглалыг дэвшүүлэн ажиллав. Үүнд:

H1: Эрчим хүчний салбарын нөхцөл байдлын талаарх ойлголт өндөр байх тусам эрчим хүчний үнэ тарифыг нэмэхэд эсэргүүцэл бага байна.

H2: Эрчим хүчний үнэ тарифын хэмжээ нь хэрэглэгчийн хувьд бага байна.

Дээрх судалгааны зорилго, таамаглалд хүрэхийн тулд эрчим хүчний салбарын талаарх мэдлэгийн түвшин нь үнэ тарифын талаарх ойлголтод хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорьсон бөгөөд судалгааг санамсаргүй түүврийн болон, зорилгод түүврийн аргаар эрчим хүчтэй холбоотой байгууллагад ажилладаг ажилтан, албан хаагчдыг хамруулахыг зорив.

2. ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСЭРГҮҮЦЛИЙН ТАЛААР СУДАЛГДСАН БАЙДАЛ

Нийгмийн салбаруудад өөрчлөлт хийх үйл явц нь нарийн төвөгтэй, олон хүчин зүйлийн нөлөөллөөс хамааралтай цогц үйл явц байдаг.

⁴ Судлаачийн Google хайлтын системээр “Эрчим хүчний үнэ чөлөөлөх” гэсэн хайлтын үр дүнд 203,000 илрэл илэрсэн. Илрэцийн дунд, үнэ чөлөөлөхийн дэмжсэн болон эсэргүүцсэн саналыг илэрхийлсэн олон тооны эх сурвалжууд байна. Үнэ чөлөөлөхийг эсэргүүцсэн нийтлэлийн агуулга ихэнхдээ эрчим хүч үйлдвэрлэгч нарт үргүй зардал өндөр байгаа тухай, зардлаа танах тухай нийтлэлүүд байна.


Өөрчлөлтийг үзэх хоёр хандлага байдаг бөгөөд хүн, нийгмийн хүчин зүйлд төвлөрдөг өөрчлөлтийн “уян хандлага”, бүтэц зохион байгуулалтад түлхүү анхаардаг “хатуу хандлага” зэрэг болно. Өөрчлөлтийн сургуулиудын үндэслэгчдийн нэг К.Левин “Уян хандлага”-ын гол төлөөлөгч бөгөөд тэрээр “Хүмүүс бол огт өөрчлөгддөггүй субъект биш бөгөөд сурах үйл явцыг нэмэгдүүлэх замаар хувь хүнийг өөрчилж болно” гэж үздэг байна. (Б.Хэрлэн, 2020) Курт Левин нь өөрчлөлтийн хэд хэдэн загвар боловсруулсан бөгөөд хамгийн түгээмэл ашиглагдсан загвар нь “Өөрчлөлтийн 3 шат”-ны загвар юм.

Курт Левиний Өөрчлөлтийн 3 шатны загвар.

Курт Левин (Kurt Lewin) өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах гурван үе шатыг дамжих хэрэгтэй гэж үзсэн [Lewin, 1947]. Үүнд:

- Гэсгээх алхам (Unfreezing): Энэ үед өөрчлөлтөд хүмүүсийн сэтгэлзүйг бэлдэх үе, өөрөөр хэлбэл агаад өөрчлөгдөх шаардлагатай талаар мэдээллээр хангах, сэдэлжүүлэх агуулга багтдаг.
- Өөрчлөлт хийх алхам (Moving): Төлөвлөгөөний дагуу өөрчлөлтөө хэрэгжүүлэх үе шат бөгөөд гэсгээлт өөрчлөлтийн бэлтгэлийг сайн хангасан тохиолдолд өөрчлөлт төлөвлөгөөний дагуу амжилттай хэрэгжих боломжтой болдог. Энэ талаар К.Левин олон тооны нийгмийн туршилтуудыг хийж, зөвхөн сэдэл төрөх бус хүний зан төлөвт өөрчлөлт гарч байж, хүн үйлдэл хийдэг гэдгийг туршилтын үр дүнгүүдээр нотолсон.
- Хөлдөөх алхам (Freezing): Өөрчлөгдсөн байдал буюу шинэ байдлыг тогтворжуулах үйл ажиллагаа бөгөөд хэрвээ хөлдөөлт буюу сүүлийн үе шатыг сайн хийхгүй бол хэчнээн сайн хийсэн өөрчлөлт тодорхой хугацааны дараа эргээд нэгдүгээр шатны өмнөх үед буцаад очих болно. Хөлдөөх үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэний дараа бүлэг бүрд шинэлэг хэлбэрийн норм тогтож, өөрчлөгдсөн шинэ нөхцөл байдалд тогтворждог.

Гэгсгээх үе шатыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?



Зураг 1 Гэгсгээх үе шатны статус quo (Status Quo)

Эх сурвалж: (Г.Цэрэн, 2021 он)

Дээрх загварт үзүүлснээр Статус Куо (Status Quo) нь өөрчлөлт хийх тэнцвэрийн үе бөгөөд энэ тэнцвэрийн байдлаас хөдлөхийн тулд эхний үе шат буюу гэгсгээлтийг хийдэг байна. Өөрчлөлтийн эхний үе шатыг зарим тохиолдолд гадны агент гэж нэрлэгдэх экспертүүдийн тусламжтайгаар хийх тохиолдол гардаг байна. Гэгсгээлтийг хийхийн тулд доорх гурван аргын аль нэгийг сонгох хэрэгтэй.

- **Жолоодох хүчийг нэмэгдүүлэх (Driving forces):** Жолоодох хүч нь тэнцвэрийн байдлаас ажилтнуудын зан төлөвийг холдуулдаг. Жишээ нь өөрчлөлтийг хүлээн авсан хүмүүсийн цалинг нэмэгдүүлэх, шагналд тодорхойлох, сургалтад хамруулах гэх мэтээр жолоодох хүчийг нэмэгдүүлж болно.
- **Хязгаарлах хүчийг бууруулах (Restraining forces):** Тэнцвэрийн байдлаас хөдлөхөд саад болж буй хүчийг бууруулдаг. Жишээ нь ажилтнуудтай уулзан санал бодлыг нь сонсон, өөрчлөлтийн дараа айх зүйл байхгүй гэдэгт итгүүлэх гэх мэтээр хязгаарлах хүчийг бууруулах боломжтой.
- **Дээрх 2 аргыг хослуулан хэрэглэх.** Тэнцвэрийн байдлаас ажилтнуудын зан төлөвийг холдуулах, тэнцвэрийн байдлаас хөдлөхөд саад болж буй хүчин зүйлсийг бууруулах аргыг нэгэн зэрэг хийх боломжтой.

Гэгсгээх алхам нь өөрчлөлтийн талаарх ойлголтыг бий болгох болон өөрчлөлтийг эсэргүүцэх эсэргүүцлийг даван туулахад чиглэгддэг (Lewin, 1947). Курт Левиний өөрчлөлтийн загварт тусгасан өөрчлөлтийн эсэргүүцэл (Resistance to change) гэх ойлголтыг олон судлаачдад санал болгосон ч, ихэнх тохиолдолд тав тухтай байдлаас гарах, байр сууриа алдах, илүү төлбөр

төлөх шаардлага үүсдэг учраас хүмүүс өөрчлөлтийг эсэргүүцдэг [Dent Goldberg, 1999]. Дэнт, Голдберг нар нь өөрчлөлтийг эсэргүүцэх шалтгаан болон даван туулах арга замуудын талаар менежментийн сурах бичгүүдэд хэрхэн туссан байгааг харьцуулан, “Боловсрол олгох (Education)”, “Оролцоог хангах (Participation)”, “Чиглүүлэх (Facilitation)”, “Хэлэлцээр хийх (Negotiation)” гэсэн аргуудыг ашиглах нь үр дүнтэй талаар дүгнэсэн байна (Dent & Goldberg, 1999). Дээрх аргуудын аль нь ч эсэргүүцэх магадлалтай бүлгийг хангалттай хэмжээний мэдээллээр хангах талаарх ойлголт болно.

Бодит байдал дээр хүмүүс бодол санаа (thoughts), мэдрэмж (feelings), хүсэл эрмэлзэл (motivation), үйлдэл (action)-ээ тодорхой хэмжээгээр хянаж, өөрийгөө эргэцүүлэн (self-reflective) бодох, хариу үйлдэл үзүүлэх (self-reactive) чадвартай байдаг. Өөрийгөө удирдах чадварыг хэрэгжүүлэхдээ хүмүүс удирдан чиглүүлэгч, сэдэл төрүүлэгч болох зан үйлийн тодорхой стандартыг баталж, өөрийн үйлдлээр дамжуулан өөрсдийн үйлдлүүдийг урьдчилан зохицуулдаг. Тиймээс хүний үйл ажиллагаа нь өөрөө бий болсон болон гадны нөлөөллийн эх үүсвэрийн харилцан үйлчлэлээр зохицуулагддаг [Bandura, 1991].

Эрчим хүчний үнэ тарифыг өөрчлөх асуудал ч мөн адил хэрэглэгчдээс өмнөхөөс их хэмжээний төлбөр төлөхийг шаардах тул эсэргүүцэлтэй тулгарах нь дамжиггүй. Гэхдээ эсэргүүцлийг даван туулж байж, цаашлаад эрчим хүчний холбогдох асуудлуудыг шийдвэрлэж байж л эдийн засгийн өсөлт, боловсруулах үйлдвэрлэлийг сэргээх, дэмжих, эдийн засгийн диверсификацийг бий болгох боломжтой болно.

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд нийт эрчим хүчний салбарын талаар ойлголттой болон ойлголтгүй гэсэн 2 бүлгийн янз бүрийн насны, янз бүрийн боловсролын түвшинтэй 510 оролцогч хамрагдсан. Судалгааны үр дүнгээс харахад нийт оролцогчдын 48 хувь нь эмэгтэй, 52% нь эрэгтэй хамрагдсан бол 77% нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй 24% нь түүнээс доош боловсролын түвшинтэй оролцогч нар хамрагдсан байна.

Хүснэгт 2 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Final question1	Answer	Frequency	Percent
Ажиллаж байгаа газар	ЭХ салбарт ажилладаг	283	55%
	ЭХ салбарт ажилладаггүй	227	45%
	total	510	100%
Боловсролын зэрэг	Магистр/Доктор	113	22%
	Бакалавр	278	55%
	Бүрэн дунд/Мэргэжлийн	95	19%
	Бүрэн бус дунд	24	5%
	total	510	100%
Хүйс	Эмэгтэй	247	48%
	Эрэгтэй	263	52%
	total	510	100%
Танай өрхийн сарын дундаж орлого	5 ба түүнээс дээш	41	8%
	3-5 сая	132	26%
	1-3 сая	274	54%
	1 сая хүртэл	63	12%
	total	510	100%
Та эрчим хүчний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?	Маш сайн мэдээлэлтэй	69	14%
	Сайн мэдээлэлтэй	161	32%
	Боломжийн мэдээлэлтэй	151	30%
	Бага зэрэг мэдээлэлтэй	101	20%
	Мэдээлэл авч чаддаггүй	28	5%
total	510	100%	

Эх сурвалж: Судлаачийн авсан анхдагч судалгааны үр дүн

Тайлбар: Судалгааг эрчим хүчний салбарт ажилладаг болон ажилладаггүй хүмүүсээс авсан хэдий ч, эрчим хүчний салбарт ажилладаг хүмүүс дунд салбарын талаар сайн мэдээлэлтэй гэж хариулах хүний тоо бага байсан болно.

Нийт оролцогчдын 14% нь эрчим хүчний салбарын талаар ойлголттой, 32% нь сайн мэдээлэлтэй, 30% нь боломжийн мэдээлэлтэй гэж өөрийгөө дүгнэсэн бол 25% нь маш бага болон мэдээлэл авч чаддаггүй гэж өөрийгөө дүгнэсэн байна. Мэдээллийн бүлэг нь нормаль тархалттай, хүйсийн харьцаа тэнцвэртэй байна. Мөн “Төвийн бүсийн эрчим хүчний систем” /ТБЭХС/ нь 631,577 (Эрчим хүчний зохицуулах хороо, 2023) өрхийн хэрэглэгчтэй бөгөөд түүврийн хэмжээг 0.95 хувь, алдаа гарах магадлалыг 5 хувь гэж үзэхэд 384 хэрэглэгчээс судалгаа авахаар гарсан бөгөөд 510 оролцогч нь түүнээс илүү байгаа тул бүрэн төлөөлөхөөр байна. Судалгааны өгөгдлийг 2024 оны 4-р сарын 10-24-ний өдрийн хооронд цуглуулсан болно. Судалгааны асуултуудын найдвартай байдлыг илтгэх Кронбахын альфа утга 0.818 (нийт 13 асуулт) байсан тул цаашид судалгааны үр дүнг ашиглах боломжтой нь харагдаж байна.

Судалгааны асуултуудыг SCALE төрлөөр боловсруулсан бөгөөд 1-5 хүртэлх онооны системээр эерэг, бууруулах, багаар мэдрэх тусам 5 оноо, сөрөг үнэлгээтэй байгаа бол 1 оноо хүртэл үнэлэхээр тогтоосон болно. Нийтлэг байдлаар 5 шатлалаар

асуусан асуултуудын дундаж хариултуудын утгыг хүснэгт 3-т нэгтгэн харууллаа.

Хүснэгт 3 Эрчим хүчтэй холбоотой асуусан зарим асуултуудад хариулсан хариултын үр дүн

Асуултууд	Mean	SD	5	4	3	2	1
Q5. Та ЭХ-ний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?	3.30	1.09	69	166	151	96	28
Q6. Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн үйл ажиллагаа явуулж чаддаг уу?	3.11	1.06	66	97	195	130	22
Q7. Та ЭХ-ний хэмнэлт хийх, ЭХ-ний төлбөр бууруулах талаар сургалт мэдээлэл авч чаддаг уу?	3.05	1.22	50	168	124	92	76
Q8. Таны төлж байгаа цахилгаан ЭХ-ний төлбөрийн хэмжээ нь танд ямар санагддаг вэ?	3.11	0.96	48	98	251	90	23
Q9. Цахилгаан, дулааны үйлчилгээнд төлж байгаа төлбөр нь таны амьдрал үйл ажиллагаанд хэр нөлөө үзүүлдэг вэ?	3.57	1.20	122	174	145	11	58
Q13. Та цахилгаан бараа худалдан авахдаа эрчим хүчний зарцуулалтын ангилал болон хэмнэлттэй эсэхийг нь шалгаж худалдан авалт хийдэг үү?	4.33	0.84	276	145	72	17	0
Q15. Цаашид эрчим хүчний үнэ тарифыг нэмэх шаардлагатай юу?	3.75	1.34	218	101	73	82	36
Q16. Хэрэв ЭХ үнийг нэмэх тохиолдолд хэдэн хувь хүртэл нэмэхийг та хүлээн зөвшөөрөх вэ?	2.91	1.52	43	22	106	153	186

Эх сурвалж: Судлаачийн авсан анхдагч судалгааны үр дүн

Тайлбар: Асуулт тус бүр дараах байдлаар 5 шатлалтай хариулт авсан болно. (Q5: 5-маш сайн мэднэ, 4-сайн мэднэ, 3- боломжийн ойлголттой, 2-сайн мэдэхгүй, 1-ямар ч ойлголтгүй), (Q6: 5-хангалттай сайн, 4-сайн, 3-боломжийн, 2-хангалтгүй, 1-маш муу), (Q7: 5-Хангалттай сайн мэдээлэл авдаг, 4-Мэдээлэл авч чаддаг, 3-Зарим мэдээллийг авч чаддаг, 2-бага зэрэг мэдээлэлтэй байдаг, 1-мэдээлэл авч байгаагүй), (Q8: 5-маш бага, 4-бага, 3-боломжийн, 4-өндөр, 1-маш өндөр), (Q9: 5-нөлөө үзүүлдэггүй, 4-бага зэрэг нөлөө үзүүлдэг, 3-мэдэхгүй, 2-нөлөө үзүүлдэг, 1-маш их нөлөөтэй), (Q13: 5-тийм, 4- заримдаа, 3-үгүй, 2-тийм сонголт байдаг гэдгийг мэдэхгүй, 1-бусад), (Q15: 5-зайлшгүй шаардлагатай, 4-нэмэх боломжтой, 3-хэвэндээ байх нь ашигтай, 2-бууруулах боломжтой, 1-мэдэхгүй), (Q16: 5-эрчим хүчний үнийг чөлөөлөх, 4-100 хүртэлх хувиар нэмэх хүртэлх хувиар нэмэх, 3-50 хүртэлх хувиар нэмэх, 2-10-20 хувиар нэмэх, 1-нэмэхгүй, мэдэхгүй)

“Q5. Та ЭХ-ний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?” гэсэн асуултад, судалгаанд оролцогчдын 46% нь “сайн мэдээлэлтэй” болон “маш сайн мэдээлэлтэй” гэж хариулсан байна. “Q6. Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн үйл ажиллагаа явуулж чаддаг уу?” гэсэн асуултад нийт хариултын 32% нь “хангалттай сайн” болон “сайн” гэж хариулсан байна. “Q7. Та цахилгаан эрчим хүчний хэмнэлт хийх, эрчим хүчний төлбөр бууруулах талаар сургалт мэдээлэл авч чаддаг уу?” гэсэн асуултад нийт хариултын 43% нь “Хангалттай сайн мэдээлэл авдаг”, “Мэдээлэл авч чаддаг” гэж хариулжээ. Дээрх гурван асуултуудад харьцангуй

мэдээлэл сайтай хүмүүсийн харьцаа олон байгаа нь, салбарт ажиллаж байгаа хүмүүсийг судалгаанд хамруулсантай холбоотой байх магадлалтай байна.

“Q5. Таны төлж байгаа цахилгаан эрчим хүчний төлбөрийн хэмжээ нь танд ямар санагддаг вэ?” гэсэн асуултад бараг тал хувь нь буюу 49% нь “Боломжийн” гэсэн хариултыг сонгосон бол, “Маш бага” болон “Бага” гэсэн хариулт нийт хариултын 28%-ийг эзэлсэн байна. Харин эсрэгээрээ “Өндөр” болон “Маш өндөр” гэсэн хариулт нийт хариултын 23% байлаа. “Q5. Цахилгаан, дулааны үйлчилгээнд төлж байгаа төлбөр нь таны амьдрал үйл ажиллагаанд хэр нөлөө үзүүлдэг вэ?” гэсэн асуултад нийт хариултын 58% нь ямар нэг байдлаар нөлөөлдөг гэж хариулсан байна.

“Q15. Цаашид эрчим хүчний үнэ тарифыг нэмэх шаардлагатай юу?” гэсэн асуултад нийт хариултын 63% нь тодорхой хэмжээнд нэмэх нь зүйтэй гэж үзэхийн хажуугаар “Q16. Хэрэв эрчим хүчний үнийг нэмэх тохиолдолд хэдэн хувь хүртэл нэмэхийг та хүлээн зөвшөөрөх вэ?” асуултад “Нэмэхгүй болон мэдэхгүй” гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлсэн (36%) байна. Үүнийг дараагаар 10-20% нэмэх нь зүйтэй (30%) гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, санал асуулгад оролцогчдын хувьд цахилгаан эрчим хүчний үнийг нэмэх нь зүйтэй гэж үзэж байгаа хэдий ч нэмэгдэх мөнгөн дүн харьцангуй хязгаарлагдмал байхыг хүсэж байна. Энэ санал асуулгад эрчим хүчний салбарт ажиллаж байгаа хүмүүсийг хамруулсан хэдий ч эрчим хүчний үнэ чөлөөлөхийг нийт санал асуулгад хамрагдагсдын дөнгөж 8% нь дэмжсэн байна.

Харьцуулсан шинжилгээний үр дүн

Эрчим хүчний салбарт ажилладаг болон ажилладаггүй гэсэн бүлгээр судалгааны үр дүнг харьцуулан шинжилсэн (Independent Sample T test) дүнг хүснэгт 4-т үзүүлэв. Эрчим хүчний салбарт ажилладаг хүмүүсийн дундаж хариултын утга эцсийн хэрэглэгчдийн дундаж хариултын утгаас өндөр буюу статистикийн хувьд 1%-ийн алдааны түвшинд ач холбогдолтойгоор зөрүүтэй үр дүн гарсан байна.

Эрчим хүчний салбарынхны хариултын хувьд “Q15. Цаашид эрчим хүчний үнэ тарифыг нэмэх шаардлагатай юу?” гэсэн асуултад дунджаар 4.21 гэсэн хариултыг өгсөн буюу салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хувьд дэмжих хандлага өндөр байна. Гэхдээ “Q16. Хэрэв ЭХ үнийг нэмэх тохиолдолд хэдэн хувь хүртэл нэмэхийг та хүлээн зөвшөөрөх вэ?” асуултын хувьд дундаж хариулт 3.40 гэсэн хариултыг өгсөн нь салбар ажиллаж байгаа хүмүүсийн хувьд ч үнэ нэмэх эсэх дээр хязгаарлалтай хандах магадлалтай гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 4 Эрчим хүчний салбарт ажилладаг болон эцсийн хэрэглэгч гэсэн ангиллаар харьцуулсан шинжилгээний үр дүн (Independent Sample T test)

Асуултууд	Эрчим хүчний салбарт ажилладаг (n=283)		Эцсийн хэрэглэгч (n=227)		T value
	Mean	S.D	Mean	S.D	
Q5. Та ЭХ-ний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?	3.730	0.840	2.750	1.121	10.952 ***
Q6. Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн үйл ажиллагаа явуулж чаддаг уу?	3.530	0.957	2.580	0.944	11.208 ***
Q7. Та ЭХ-ний хэмнэлт хийх, ЭХ-ний төлбөр бууруулах талаар сургалт мэдээлэл авч чаддаг уу?	3.510	1.001	2.470	1.231	10.342 ***
Q8. Таны төлж байгаа цахилгаан ЭХ-ний төлбөрийн хэмжээ нь танд ямар санагддаг вэ?	3.370	0.862	2.800	0.975	6.907 ***
Q9. Цахилгаан, дулааны үйлчилгээнд төлж байгаа төлбөр нь таны амьдрал үйл ажиллагаанд хэр нөлөө үзүүлдэг вэ?	3.750	1.166	3.350	1.219	3.690 ***
Q13. Та цахилгаан бараа худалдан авахдаа эрчим хүчний зарцуулалтын ангилал болон хэмнэлттэй эсэхийг нь шалгаж худалдан авалт хийдэг үү?	4.470	0.716	4.160	0.946	4.151 ***
Q15. Цаашид эрчим хүчний үнэ тарифыг нэмэх шаардлагатай юу?	4.210	1.112	3.180	1.379	9.105 ***
Q16. Хэрэв ЭХ үнийг нэмэх тохиолдолд хэдэн хувь хүртэл нэмэхийг та хүлээн зөвшөөрөх вэ?	3.400	1.373	2.310	1.476	8.554 ***

Эх сурвалж: Судлаачийн авсан анхдагч судалгааны үр дүн

Тайлбар: *** нь 99%-ийн итгэлцлийн түвшинд ач холбогдлыг илэрхийлнэ.

“Q13. Та цахилгаан бараа худалдан авахдаа эрчим хүчний зарцуулалтын ангиллыг шалгаж худалдан авалт хийдэг үү гэсэн асуултын дундаж утга (4.21, 4.16) байгаа нь судалгаанд оролцогч аль аль бүлгүүдийн хувьд эрчим хүчний хэмнэлт хийх хандлагатай байгааг харуулж байна. (Хүснэгт 4)

“Q5. Та ЭХ-ний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?” асуултад хариулсан байдлаар буюу салбарын талаарх мэдлэгийн түвшний зөрүүгээр бусад асуултад хэрхэн хариулсан байгааг харьцуулсан үр дүнг хүснэгт 5-д илэрхийллээ. Бүхий л асуултаудын хувьд салбарын талаарх мэдлэгийн түвшин нэмэгдсэн тохиолдолд эрчим хүчний үнийг нэмэхийг дэмжих хандлагатай болж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 5 Эрчим хүчний салбарын мэдлэг, мэдээллийг түвшнээр харьцуулсан судалгааны үр дүн (Independent Sample T test)

	Загвар 1: Эцсийн хэрэглэгч			Загвар 2: Эрчим хүчний салбарт ажилладаг						
	B	Std. Error	Beta	t value	Sig.	B	Std. Error	Beta	t value	Sig.
Constant	-0.251	0.271		-0.924	0.357	0.100	0.377		0.264	0.792
Q5. Та ЭХ-ний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?	0.255	0.077	0.217	3.327	0.001	0.086	0.073	0.064	1.189	0.235
Q7. Та ЭХ-ний хэмнэлт хийх, ЭХ-ний төлбөр бууруулах талаар сургалт мэдээлэл авч чаддаг уу?	0.114	0.071	0.107	1.620	0.107	0.168	0.060	0.148	2.809	0.005
Q8. Таны төлж байгаа цахилгаан ЭХ-ний төлбөрийн хэмжээ нь танд ямар санагддаг вэ?	0.669	0.079	0.495	8.483	0.000	0.558	0.067	0.424	8.367	0.000
Q9. Цахилгаан, дулааны үйлчилгээнд төлж байгаа төлбөр нь таны амьдрал үйл ажиллагаанд хэр нөлөө үзүүлдэг вэ?	0.060	0.056	0.056	1.075	0.283	0.153	0.049	0.158	3.147	0.002
Өрхийн орлого (1-3 сая)	-0.082	0.178	-0.031	-0.458	0.648	0.236	0.203	0.103	1.163	0.246
Өрхийн орлого (3-5 сая)	-0.035	0.204	-0.011	-0.171	0.864	0.557	0.222	0.218	2.511	0.013
Өрхийн орлого (5 саяас дээш)	0.130	0.270	0.027	0.479	0.632	0.736	0.277	0.174	2.654	0.008
N	226					282				
Adjusted R ²	0.486					0.353				
F value	31.510					23.001				

Эх сурвалж: Судлаачийн авсан анхдагч судалгааны үр дүн

Тайлбар: < нь 99%-ийн итгэлцлийн түвшинд ач холбогдолтойгоор зөрүүтэйг илэрхийлнэ. Тод тоогоор харьцуулсан шинжилгээний хувьд өндөр үнэлгээтэйг илэрхийлэв.

Ялангуяа “Цаашид эрчим хүчний үнэ тарифыг нэмэх шаардлагатай юу?” гэсэн асуултад салбарын талаар маш сайн мэднэ гэж хариулсан бүлгийн дундаж оноо 4.46 болж, үнийг нэмэхийг дэмжих хандлага өндөр байна. Гэсэн хэдий ч, үнийг хэр хэмжээнд нэмэх вэ гэдэг асуултад 3.77 гэсэн дундаж хариулыг өгсөн буюу маш сайн мэдэж буй бүлгийн дунд ч үнэ чөлөөлөхийг бүрэн дэмжихгүй байгаа дүр зураг харагдаж байна (хүснэгт 5).

Хүснэгт 6 Эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг дэмжихэд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ (Regression)

	Загвар 1: Эцсийн хэрэглэгч			Загвар 2: Эрчим хүчний салбарт ажилладаг						
	B	Std. Error	Beta	t value	Sig.	B	Std. Error	Beta	t value	Sig.
Constant	-0.251	0.271		-0.924	0.357	0.100	0.377		0.264	0.792
Q5. Та ЭХ-ний салбарын талаар хэр мэдээлэлтэй вэ?	0.255	0.077	0.217	3.327	0.001	0.086	0.073	0.064	1.189	0.235
Q7. Та ЭХ-ний хэмнэлт хийх, ЭХ-ний төлбөр бууруулах талаар сургалт мэдээлэл авч чаддаг уу?	0.114	0.071	0.107	1.620	0.107	0.168	0.060	0.148	2.809	0.005
Q8. Таны төлж байгаа цахилгаан ЭХ-ний төлбөрийн хэмжээ нь танд ямар санагддаг вэ?	0.669	0.079	0.495	8.483	0.000	0.558	0.067	0.424	8.367	0.000
Q9. Цахилгаан, дулааны үйлчилгээнд төлж байгаа төлбөр нь таны амьдрал үйл ажиллагаанд хэр нөлөө үзүүлдэг вэ?	0.060	0.056	0.056	1.075	0.283	0.153	0.049	0.158	3.147	0.002
Өрхийн орлого (1-3 сая)	-0.082	0.178	-0.031	-0.458	0.648	0.236	0.203	0.103	1.163	0.246
Өрхийн орлого (3-5 сая)	-0.035	0.204	-0.011	-0.171	0.864	0.557	0.222	0.218	2.511	0.013
Өрхийн орлого (5 саяас дээш)	0.130	0.270	0.027	0.479	0.632	0.736	0.277	0.174	2.654	0.008
N	226					282				
Adjusted R ²	0.486					0.353				
F value	31.510					23.001				

Эх сурвалж: Судлаачийн авсан анхдагч судалгааны үр дүн

Тайлбар: Хамаарах хувьсагч нь “Q15 Цаашид эрчим хүчний үнэ тарифыг нэмэх шаардлагатай юу?”, “Q16. Хэрэв эрчим хүчний үнийг нэмэх тохиолдолд хэдэн хувь хүртэл нэмэхийг та хүлээн зөвшөөрөх вэ?” асуултаудын дундаж утга буюу эрчим хүчний үнэ тарифыг нэмэх эсэх талаарх санал бодлыг авч үзэв. Статистикийн хувьд ач холбогдол бүхий коэффициентүүдийг тод үсгээр илэрхийлэв.

Эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг дэмжихэд нөлөөлөх хүчин зүйлсийн регрессийн шинжилгээний үр дүнг хүснэгт 6-д үзүүлээ. Регрессийн шинжилгээг эрчим хүчний эцсийн хэрэглэгч болон эрчим хүчтэй холбоотой байгууллагад ажилладаг гэсэн хоёр загвар болгон хувааж шинжилгээ хийв (хүснэгт 6). Эрчим хүчний чиглэлийн байгууллагад ажилладаг эсэхээс үл хамааран “Q8. Таны төлж байгаа цахилгаан ЭХ-ний төлбөрийн хэмжээ нь танд ямар санагддаг вэ?” гэсэн хүчин зүйлсийн бетта утга харилцан 0.495, 0.424 гарч, статистикийн ач холбогдолтой гарсан байна. Өөрөөр хэлбэл төлж буй төлбөрийн хэмжээ бага гэж үзэж байгаа тохиолдолд төлбөр нэмэхийг дэмжих магадлалтайг илэрхийлж байна. Ажиллаж буй байгууллагын ялгаатай байдал, өөрөөр хэлбэл салбарт оролцооны түвшний ялгаатай байдлаас шалтгаалан эцсийн хэрэглэгчийн хувьд салбарын талаарх мэдлэг, мэдээллийн түвшин нэмэгдэх тусам үнэ тарифын өөрчлөлтийг дэмжих хандлага ($\beta=0.217$, $t=3.327$) нэмэгдэж байна. Энэ үр дүн (Хүснэгт 5)-д үзүүлсэн салбарын талаарх мэдлэг, мэдээллийн хэмжээ нэмэгдэх тусам илүү үнэ тарифын өөрчлөлтийг дэмжинэ гэсэн харьцуулсан шинжилгээний хариутай нийцэж байна. Эцсийн хэрэглэгч бүлгийн регрессийн тэгшитгэл нь дараах байдалтай тодорхойлогдсон байна.

$$\text{ҮНЭ НЭМЭХ} = -0.251 + 0.255 * \text{Мэдлэг} + 0.114 * \text{Мэдээлэл} + 0.669 * \text{Төлбөр мэдрэмж}$$

Харин салбарт ажиллаж буй хүмүүсийн хувьд мэдлэг, мэдээллийг мэддэг гэж хариулсан түвшин үнэ тарифыг дэмжихэд эергээр төдийлөн нөлөөлж чадахгүй байна ($\beta=0.064$, $t=1.189$). Салбарт ажилладаг хүмүүсийн хувьд “Цахилгаан, дулааны үйлчилгээнд төлж байгаа төлбөр нь таны амьдрал үйл ажиллагаанд хэр нөлөө үзүүлдэг вэ ($\beta=0.158$, $t=3.147$).”, “Танай өрхийн сарын дундаж орлого 3-5 сая бол ($\beta=0.218$, $t=2.511$)”, “Өрхийн орлого 5 саяас дээш бол ($\beta=0.174$, $t=2.654$) гэсэн үр дүн гарсан байна. Салбарт ажилладаг бүлгийн хувьд тэгшитгэл дараах хэлбэртэй байна.

$$\text{ҮНЭ НЭМЭХ} = 0.1 + 0.168 * \text{Мэдээлэл} + 0.558 * \text{Төлбөр мэдрэмж} + 0.153 * \text{Нөлөөлөл}$$

Салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хувьд эрчим хүчний үнэ тарифыг бага гэж мэдэрч байх тусам цаашид үнэ нэмэхийг зөвшөөрсөн хандлагатай байгаа бөгөөд мөн орлогын түвшин нэмэгдэх нь үнэ тарифыг нэмэх хандлагыг өсгөж байна. Үүнээс авч үзэхэд эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтөд нөлөөлөх суурь хүчин зүйл нь эрчим хүчний салбарын талаарх ерөнхий мэдлэг байгаа бөгөөд мэдлэг мэдээллийг нэмэгдүүлсэн

тохиолдолд бусад хүчин зүйлүүд болох үнэ тарифыг мэдрэх байдал, орлого зэрэг хүчин зүйлүүд нь ач холбогдолтой болж ирсэн байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд дэвшүүлсэн 2 таамаглал нь нотлогдож байгаа бөгөөд дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

Оролцогчид нь салбар дахь оролцооны хэлбэрээс үл хамааран эрчим хүчний төлбөрт төлж байгаа төлбөрийг 77% нь боломжийн болон бага, маш бага гэж дүгнэж байна.

Судалгаанд оролцогчдын 63 хувь нь эрчим хүчний үнэ тарифыг нэмэх зүйтэй гэдэг байр суурьтай байгаа бол 36% нь 50 хувиас дээш хувь нэмэхийг дэмжинэ гэсэн хариулт өгсөн. Хэдийгээр цахилгаан эрчим хүчний үнийг нэмэх нь зүйтэй гэж үзэж байгаа хэдий ч нэмэгдэх мөнгөн дүн харьцангуй хязгаарлагдмал байхыг хүсэж байна. Мөн оролцогчдын 58% нь эрчим хүчний төлбөр нь амьдралд ямар нэг байдлаар нөлөөлдөг гэж хариулсан байна.

Эрчим хүчний салбарт ажиллаж байгаа (ойлголттой) бүлгийн хувьд үнэ тарифыг нэмэх эсэх талаарх асуултын дундаж 4.21 гэсэн харьцангуй өндөр эерэг хариулт өгсөн боловч хэдэн хувиар нэмэх талаарх асуултын дундаж 3.40 байгаа нь салбар ажиллаж байгаа хүмүүсийн хувьд ч үнэ чөлөөлөхийг бүрэн дэмжихгүй байгааг илэрхийлж байна дүгнэж болохоор байна.

Судалгаанд оролцогчид нь төлбөрийн хэмжээ бага гэж үзэж байх тусам төлбөр нэмэхийг дэмжих хандлага өсөж байгаа бөгөөд уг үзүүлэлт нь салбарын талаарх мэдлэгтэй статистикийн ач холбогдол бүхий хамааралтай буюу салбарын мэдлэг нэмэгдэх тусам хэрэглэгч нь төлж байгаа төлбөрийн хэмжээ бага гэж мэдэрч байна.

Салбарын талаарх мэдлэгийн түвшин нэмэгдсэн тохиолдолд эрчим хүчний үнийг нэмэхийг дэмжих хандлагатай болж байгаа нь бүх асуултуудын хувьд харагдаж байна.

Салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хувьд эрчим хүчний үнэ тарифыг бага гэж мэдэрч байх тусам цаашид үнэ нэмэхийг зөвшөөрсөн хандлагатай байгаа бөгөөд мөн орлогын түвшин нэмэгдэх нь үнэ тарифыг нэмэх хандлагыг өсгөж байна.

Эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтөд нөлөөлөх суурь хүчин зүйл нь эрчим хүчний салбарын талаарх ерөнхий мэдлэг байгаа

бөгөөд мэдлэг мэдээллийг нэмэгдүүлсний дараа бусад хүчин зүйлүүд болох үнэ тарифыг мэдрэх байдал, орлого, боловсролын түвшин зэрэг хүчин зүйлүүд нь ач холбогдолтой болж ирсэн байна.

Цаашид эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийн талаар олон нийтэд сурталчлах мэдээллийг нийтлэхдээ зөвхөн хэмнэх бус, салбарын асуудлуудыг л дөвийлгөх бус, эрчим хүчний салбарын өөрчлөлт, шинэчлэлт нь цаашдын улс орны эдийн засгийг өсөлт хөгжилд хэрхэн нөлөөлөх талаар, төрөөс баримталж буй бодлоготой уялдуулан сурталчилснаар эсэргүүцлийг бууруулах боломжтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Bandura, A. (1991). Social Cognitive Theory of Self - Regulation. *Organizational Behavior and Human Decision Processes*, 248-287.
- Dent, E., & Goldberg, S. (1999). Challenging “Resistance to Change”. *The Journal of Applied Behavioral Science*, 25-41. doi:<https://doi.org/10.1177/0021886399351003>
- Lewin, K. (1947). Frontiers in group dynamics - Concept, method, reality in social sciences; Social equilibria and social change. *Human relations*, 5-41.
- Maic Rakitta, J. W. (2021/09/06). Cognitive Biases in Building Energy Decisions. Mpdf.com. trade map. (2022). trademap.org.
- А.Отгонжаргал, Б. (2014). Эрчим хүчний зах зээлийн загварууд, өрсөлдөөний бий болгох нь. . Slideshare, 1-22.
- Б.Хэрлэн, Д. В. (2020). Өөрчлөлтийн удирдлага. Улаанбаатар хот: Арвайбархан ХХК.
- Г.Цэрэн. (2021 он). Байгууллагын зан төлөв. Улаанбаатар хот: Монгол улсын их сургууль, Бизнесийн сургууль.
- Д.Үлэмж. (2024 оны 1 13). Эрчим хүчний салбар эдийн засгийн өсөлтийг хойш нь татсаар. (Б.Эрдэнэчимэг, Ярилцагч)
- Диспетчерийн үндэсний төв. (2020,2021,2022 он). Үйл ажиллагааны тайлан. Улаанбаатар.

Диспетчерийн үндэсний төв. (2022 он). Үйл ажиллагааны тайлан.
Улаанбаатар хот: Диспетчерийн үндэсний төв.

Монгол улсын үндэсний статистикийн хороо. (2019 он). Монгол улсын эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ. Улаанбаатар.

О.Бавуудорж, Д. Г. (2022). Монгол улсын эрчим хүчний төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулах нь. Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ой- Эрчим хүчний шилжилт ба тогтвортой хөгжил эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 10-16.

УИХ. (2021 оны 12 30). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431>-ээс Гаргасан

Үндэсний аудитын хорр. (2021.12.16). Эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарифын зохицуулалт, үр нөлөө. Улаанбаатар.

ЦЭХ-ний үнэ тариф. (2022 оны 10 28). Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ: <https://www.tog.mn/une/1>-ээс Гаргасан

Ч.Зундуйсүрэн, Ё. (2002). Эрчим хүчний менежмент. Улаанбаатар: Шинжлэх ухаан технологийн их сургууль, эрчим хүчний сургууль.

Эрчим хүчний зохицуулах хороо. (2023). Тайлан 2022. Улаанбаатар хот.

Эрчим хүчний зохицуулах хороо. (2023). Эрчим хүчний статистикууд. Эрчим хүчний зохицуулах хороо: <https://online.fliphtml5.com/seigx/utct/#p=32>-ээс Гаргасан

Эрчим хүчний зохицуулах хороо. (2023/12/21). Монгол улсын эрчим хүчний системийн мэдээ. Улаанбаатар.

Эрчим хүчний яам. (2023). Эрчим хүчний 100, 101 жилийн ойн мэдээлэл. Улаанбаатар хот.